



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

134 /134/

2021.09.14

ҮЙЛ ЯВДАЛ

Д.Ганзориг: ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ШИНЭ ЗУУНЫ ТҮҮХИЙГ БИЧИЛЦЭХЭД ТА БҮХНИЙ ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР ТУН ИХ

Монголын ууган боловсролын байгууллага УБХИС-ийн 91 дэх удаагийн төгсөгчдөд цэргийн цол гардуулах, Зэвсэгт хүчний ангиудад томилох ёслолын ажиллагаа боллоо. Ёслолын ажиллагаанд ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, нэгдүгээр орлогч дарга, хурандаа С.Ганбямба, АУГ-ын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, Зэвсэгт хүчний Материал, техникийн газрын дарга, бригадын генерал М.Мөнхбаяр болон төрлийн цэргийн командлалын удирдлагууд оролцлоо.

ЗХЖШ-ын даргын цэргийн цол олгох, албан тушаалд томилох тухай тушаалыг уншиж танилцуулсны дараагаар төгсөгчдөд цол, үнэмлэх, томилолтын хуудсыг гардуулсан юм.

Энэ үеэр дэслэгч генерал Д.Ганзориг төгсөгчдөд хандан "Өнөөдөр та бүгдийн хувьд амьдралын нэгэн шинэ хуудас нээгдэж байна. Өөрөөр хэлбэл Зэвсэгт хүчний байнгын бие бүрэлдэхүүний эгнээнд шилжсэн гэсэн үг. Манай Зэвсэгт хүчин энэ цаг үед түүхт 100 жилийн ойтойгоо золгосон. Өнгөрсөн 100 жилийн хугацаанд өрнөсөн үйл явдлуудыг эргээд хараахан бид Монгол Улсын хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтын тэргүүн эгнээнд байсаар иржээ. Түүхт 100 жилийн ойтойгоо давхцаж Зэвсэгт хүчний эгнээнд шилжсэн нь та бүхний амьдралд дурсахуйц, онцгой үйл явдал гэж бодож байна. Офицер, ахлагчийн албанд элссэнээр том хариуцлагыг дааж явна гэдгээ хэзээ ч мартаж өсгүй. Зэвсэгт хүчний шинэ зууны түүхийг бичилцэхэд та бүхний оруулах хувь нэмэр, үүрэг оролцоо тун их шүү. Энэ хэрэгцээ шаардлагын үүднээс өөрсдийгөө цаг ямагт боловсруулж, хөгжүүлж, цэргийн хэргийн мэдлэгээс гадна амьдралын ухаанд сайтар суралцахыг чухалчлан захъя. Сайтар төлөвлө. Төлөвлөгөөнд чинь та бүхний хувийн амьдрал багтсан байх ёстой. Ажил, албандаа амжилт гаргахын нэг үндэс нь гэр бүлийн тогтвортой байдал. Ингээд та бүгдийн Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх их үйлсэд амжилт, гэр бүл, үр хүүхдэд нь аз жаргал, эрүүл энхийг хүсье" гэв.

Үүний дараа төгсөгчдийг төлөөлж дэслэгч Б.Ууганбат "Цэргийн эрдэмд шамдан боловсорч, эх орноо



батлан хамгаалах чин хүслээр бялхаж явсан сонсогч үе минь хамгийн сайхан, хамгийн дурсамжтай цаг хугацаа. Суралцах хугацаандаа аранз үүрч, буу мөрлөн, үзэг барьж эрдэмд шамдан байж цэрэг хүний тэсвэр тэвчээрийг бие сэтгэлээрээ мэдэрч үзсэн минь хамгийн том бахархал гэж боддог. Зэвсэгт хүчний 100 жилийн ойгоороо бахдам гавьяат дайчдынхаа үргэлжлэл болж шинэхэн офицер болж байгаадаа баяртай байна" гэв. Мөн дэд ахлагч М.Намсрай "Өнөөдрөөс миний

бие үеийн нөхдийн хамт Зэвсэгт хүчний ахлагчийн албанд элсэж байна. Цэрэг хүний хувьд улс орноо батлан хамгаалах үйлсэд хоёргүй сэтгэлээр зүтгэж, хувь нэмрээ оруулах ёстой. Өнгөрсөн жилийн хугацаанд цэрэг хүний эр зориг, тэсвэр тэвчээртэй байх чанарт суралцаж, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлан ёс зүйтэй зөв хүн болон төлөвшиж өнөөдөр эх орныхоо төлөө зүтгэх эрхэм үүргийг хүлээн авлаа" хэмээсэн юм.

Түүхэнд энэ өдөр

1996 он:

"Цэргийн ар талыг зохион байгуулах нь" сэдэвт Монгол Улс, ХБНГУ-ын хамтарсан сургалт семинар Улаанбаатар хотод өндөрлөжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
14	6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
33	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,844.00	2,855.00
EUR	3,335.0	3,389.0
CNY	440.0	444.40
RUB	38.00	40.00
JPY	25.63	26.12
KRW	2.34	2.47

ЗУРХАЙ

2021.09.14 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 8/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН ГУРВАН ХӨХ ХӨХӨГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:
Нас уртасна.
Наран ургах, шинжих:
06.28-19.08
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Тийн мэдэхүй
Суудал:
Шороо

Аргын тооллын 9 дүгээр сарын 14, Ангарга гараг. Билгийн тооллын 8, Гар одтой, хөхөгчин үхэр өдөр. Өдрийн наран 6 цаг 28 минутад мандан, 19 цаг 08 минутад жаргана. Тухайн өдөр могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адууус муулах, лус, тахих, мал арилжиж, буг дарах, газрын ам бооход сайн. Цөөрөм байгуулах, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Модон хохимой өдөр.

Үс шинээр үргээлгэх буюу засуулбал нас уртасна.

"ХАМТЫН ХУВЬ ЗАЯА-2021" АМЖИЛТТАЙ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



БНХАУ-ын Хэнань мужийн Жумадан хотод байрлах Хятадын Ардын Чөлөөлөх Армийн энхийг дэмжих ажиллагааны "Куесан" сургалтын төвд "Хамтын хувь заяа-2021" олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургууль төлөвлөгөөний дагуу явагдаж, сургуулийн I шат-салаадын сургууль 9 дүгээр сарын 11-ний өдөр өндөрлөв.

Сургуулийн нэгдүгээр шатанд Монгол Улсын Зэвсэгт хүчний мотобуудлагын салаа БНХАУ-ын ХАЧА-ийн цэргийн алба хаагчдын үндсэн зэвсэг болох "QBZ92" загварын 5.8мм-ийн автомат буу болон "92В" загварын хуягт тээвэрлэгчийг хүлээн авч, жолоодлогын дадлага болон буудлагын зэвсгийн дасгал боловсруулсан бөгөөд "Түр ажиллагааны

бааз байгуулах", "Баазын харуул хамгаалалт болон явган эргүүл", "Чухал хүний хамгаалалт", "Цувааны хамгаалалт", "Энгийн иргэдийг хамгаалах", "Террорист үйлдлийг сөрөх тусгай ажиллагаа" сэдэвт хичээлүүдийг онол, дадлагаар хэргийн байрлалд зохион байгууллаа.

Сургуулийн нэгдүгээр шатны төгсгөлд мотобуудлагын салаа "Түр ажиллагааны бааз байгуулах", "Цувааны хамгаалалт" сэдэвт үзүүлэх сургалтыг зохион байгуулсан. Үзүүлэх сургалтаар цуваагаар хөдөлгөөн үйлдэх үед халдлагыг няцаах болон "Ажиллагааны түр бааз" байгуулах, баазын байрлалаас зэвсэглэсэн этгээдүүдийн халдлагыг няцаах зэрэг цагийн байдалд НҮБ-ын хүч хэрэглэх дүрмийн дагуу хариу арга



хэмжээ авч, тавигдсан үүргийг амжилттай биелүүллээ.

Үзүүлэх сургалтыг Хятадын хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд олон нийтэд шууд дамжуулж, ХАЧА-ийн "Төв" цэргийн тойргийн удирдлагууд үзэж сонирхсон.

ХАЧА-ийн энхийг дэмжих ажиллагааны "Куесан" сургалтын төвийг НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх ЦАХ, цэргийн багийн ажиллагааны өмнөх сургалт, бэлтгэл, түүнчлэн олон улсын хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах зорилгоор 2019 онд байгуулсан бөгөөд дулаан орны байгаль, цаг уурын онцлог, ард иргэдийн аж амьдралын байдал зэрэгт нийцүүлсэн дуурайлган үзүүлэх төхөөрөмжлэлийг иж бүрнээр тоногдосон, ялангуяа

Африкийн нөхцөл байдлыг сайтар тусгаж төхөөрөмжилсөн нь дадлага, сургалтыг бодит цагийн байдалд ойртуулан олон талт байдлаар үр дүнтэй зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлжээ.

Монгол Улсын Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн оролцож буй энхийг дэмжих ажиллагааны "Хамтын хувь заяа 2021" олон улсын сургуулийг БНХАУ цаашид 2 жил тутамд зохион байгуулахаар төлөвлөж байгаа аж.

Тус сургалт нь Зэвсэгт хүчний Энхийг дэмжих ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх, хоёр улсын цэргийн хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Ахмад Г.ГАНСҮХ

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 252,254 +2351	ЭДГЭРСЭН 242,618 +1280	НАС БАРСАН 1012 +10
-----------------------------------	---------------------------	------------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4889 +83	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 191	ЭДГЭРСЭН 4606
-----------------------------	----------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 223,368,662
Эдгэрсэн Нийт: 199,873,841
Нас барсан Нийт: 4,608,597

Үйл явдал

ИТГЭМЖЛЭЛЭЭ 4 ЖИЛЭЭР СУНГУУЛЛАА



итгэмжлэлийн гэрчилгээ гардан авлаа. Ингэснээр Зэвсэгт хүчний Нэгдсэн лаборатори нь Монгол Улсын Зэвсэгт хүчинд хэмжлийн нэгдмэл байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга, баталгаажуулалт, хүнс, ахуйн хэрэглээний болон мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн, шатахуун, тос тосолгооны материал, химийн хорт бодис, уусмалд сорилт шинжилгээ хийж, чанар байдлыг тодорхойлон, мал, амьтанд мал эмнэлгийн үзлэг, оношилгоо үйлчилгээ явуулах эрх зүйн орчин бүрэлдэж байгаа юм.

Зэвсэгт хүчний Нэгдсэн лаборатори нь "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага" MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагыг бүрэн хангаж 2023 оноос хойш 7-н удаа итгэмжлэгдэж, 2020 оын 10 дугаар сарын 1-нд сорилтын 3, хэмжил зүйн 1 лаборатори

3.Хэмжил зүйн лаборатори Зэвсэгт хүчинд ашиглагдаж, хадгалагдаж байгаа хэмжлийн 6 төрлөөр шалгалт тохируулга баталгаажуулалт хийх эрхээ авсан.

бүтээгдэхүүнд физик,хими, нян судлалын үзүүлэлтээр; -Эмгэгтэй дээжид нян судлалын үзүүлэлтээр; -Ям, бруцеллээ, сүрьеэ, адууны трипаносомоз, боом өвчний үүсгэгчийг ийлдэс судлалын шинжилгээний аргаар тус тус шинжлэхээр итгэмжлэлийн хүрээгээ тэлсэн.

4. Шатахууны лаборатори нь Зэвсэгт хүчин, гэрээт аж ахуйн нэгж байгууллагын автобензин, тос, тосолгооны материал, тусгай шингэн, дизель түлш, ТС-н дээжинд хяналтын болон иж бүрэн шинжилгээ хийх, тэдгээрийн төрөл, хадгалалтын хугацааг тогтоож тоон болон чанарын хяналт тавьж ажилладаг.

5. Химийн лаборатори нь Зэвсэгт хүчний анги, салбаруудад ашиглагдаж, хадгалагдаж байгаа



үнэлгээгээр орж, "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага" MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагыг бүрэн хангаж 2025 он хүртэл итгэмжлэлээ 4 жилээр сунгуулан Үндэсний итгэмжлэлийн газраас 2021 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр

багаж, тоног төхөөрөмжөөр хангагдан ажиллаж байна. 1. Эрүүл зүй бичил амь судлал, химийн лаборатори нь Хүнс, ахуйн химийн бүтээгдэхүүнд физик, хими, нян судлалын үзүүлэлтээр; 2. Мал эмнэлэг, бактери шинжилгээний лаборатори нь Малын гаралтай хүнсний түүхий

цацраг идэвхит үүсгүүрийн хадгалалт, хамгаалалт чанар байдлыг тодорхойлж түүнтэй ажиллагааг аюулгүйн зааварчилгаа өгч ажилладаг. ЗХНЛ нь covid 19 цар тахалтай энэ цаг үед лабораторийн үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

"ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ БЭЛТГЭЛ" СУРГАЛТ ЯВАГДАЖ БАЙНА

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2021 оноос цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж буй иргэдийн "Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл" сургалтыг 2021 оны 9 дүгээр сарын 6- 9-ний хооронд халдвар хамгааллын дэглэмийг чанд сахин зохион байгуулж байна. Сургалтын хугацаанд цэргийн хэргийн мэдлэг, дадлага олгохоос гадна Даланзадгад сумын Гурвансайхан хорооллын модны 80га талбайн хогийг цэвэрлэх, сумын малчин Мөнхөөгийн таана түүж өгөх зэрэг ажлыг хийж гүйцэтгэв.



Дэд хурандаа Д.УЛАМБАЯР

АХЛАХ АХЛАГЧ Т.РЭНЦЭНБАДАМД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлах Хилийн цэргийн 0108 дугаар ангийн, ахлах ахлагч, спортын мастер Т.Рэнцэнбадам өмнөд хилийн отрядаас умард хилийн отрд

хүртэл буюу Сэлэнгэ аймаг хүртэл 1100 км-ын холын зайд гүйхээр замдаа гарсан билээ. Тэрээр Дорноговь аймгийн Хилийн цэргийн 0108 дугаар ангиас Сэлэнгэ аймгийн Алтанбулаг

боомтын 652 дугаар тэмдэгт хүртэл нийт 1100 километрийг туулж, Хил хамгаалах байгууллагын 88 жилийн ойн баярын өдөр буюу 9 дүгээр сарын 17-ны өдөр бариандаа орохоор тооцон гүйлтээ үргэлжлүүлж байгаа юм. Хилчин бүсгүй 40 дэх өдрийнхөө гүйлтээр 1100 км замынхаа 90 гаруй хувийг буюу 916 км замыг туулж 9 дүгээр сарын 9-ний өдөр Дархан-Уул аймагт ирж түр амралт хийлээ. Дархан-Уул аймагт орж ирэх үед нь аймгийн Цэргийн штабын хамт олон болон Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн удирдлага, хамт олон хүлээн авч хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг болон дурсгалын зүйл гардуулж цаашдын нь гүйлтэнд нь амжилт хүслээ.

ӨМНӨД СУДАНААС МЭДЭЭЛЖ БАЙНА



НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, энхийг сахиулах ажиллагааны тэргүүн Жан-Пьер Лакруа Өмнөд Судан Улсад 9 дүгээр сарын 9-12-ны өдрүүдэд айлчиллаа. Жуба бүсийн командлагч, бригадын генерал Б.Эрдэнэбат хүчний штабаас өгсөн үүргийн дагуу Жуба бүсийн командлалын БНХАУ-ын хүндэт харуул угтан авах бэлтгэл ажлыг хангуулж 9 дүгээр сарын 12-ны өдөр хүндэт зочныг угтан авахад Хүчний командлагч, орлогч дарга нартай хамт байлцсан юм.

Айлчлалын төгсгөлд ноён Жан-Пьер Лакруа хэлсэн үгэндээ "НҮБ дахь манай хамт олон, хүмүүнлэгийн үйлс, энхийг сахиулах, хөгжлийн тусламж, эмэгтэйчүүд, охид,

хүүхдүүдийг хамгаалах үүргээ сайн гүйцэтгэж байгаа гэдгийг би хүн бүрд баталж хэлэхийг хүсэж байна. Өмнөд Суданы ард түмнийг энх тайвнаар урагшлахад чадах бүхнээ үргэлжлүүлэн хийх болно" гэв.

Мөн тэрээр Нил мөрний дээд мужийн Малакал хотод очиж, эндхийн үер, мөргөлдөөний аймшигт үр дагаврыг өөрийн нүдээр харсан бөгөөд USG Lasgoix мужийн эрх баригчид болон хүмүүнлэгийн түншүүдтэй уулзаж, нүүлгэн шилжүүлсэн хүмүүст тулгарч буй бэрхшээлийг сонсов. Түүнчлэн Ерөнхийлөгч Салва Кири, Батлан хамгаалахын сайд Анжелина Тени нартай уулзаж тодорхой сэдвүүдээр ярилцсан байна.

УЛААНБААТАРТ ТАВТАЙ МОРИЛ



Нийслэл хотод жил бүр 70-80 мянган оюутан сурагч хөдөө орон нутгаас ирж, МСҮТ, их, дээд сургуульд суралцдаг. Тэдний хувьд хотод дасан зохицох, зорьсон газраа саадгүй зорчихоос эхлээд багагүй бэрхшээлтэй тулгардаг. Тиймээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран шинэ оюутнуудад зориулан "Улаанбаатарт тавтай морил" арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд

50 гаруй цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагч оролцон оюутнуудад зориулсан гарын авлагыг зарим их, дээд сургууль, номын сан, оюутны дотуур байр, соёл мэдээллийн байгууллагуудын ойр орчимд тарааж хэрхэн хотын соёлтой иргэн байх тухай уриалга хүргэлээ.

Гарын авлагад Улаанбаатар хотын иргэний мэдэж байх анхан шатны мэдээллүүдийг багтаасан бөгөөд нийтийн эзэмшлийн эд зүйлс, ногоон байгууламжийг хэрхэн хамгаалах, хотын иргэний соёл, дадлын талаар дурдсан байна. Мөн автобусны чиглэл, цагийн ажил, онцгой байдал, цагдаа, галын дуудлага, түргэн тусламжийн болон номын сангуудын утасны жагсаалтыг ч багтаажээ.

ШОНХРУУДЫН АМЖИЛТ ҮРГЭЛЖИЛСЭЭР



Энэ сарын 6-ны өдөр нээлтээ хийсэн Зэвсэгт хүчний 2021 оны аварга шалгаруулах цэргийн 3 төрөлт, цэрэгжлийн буудлага, туухай өргөлт, цэрэг спортын цогцолборын зуны олон төрөлт, саадын зурвасын тэмцээнүүдийг Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн баг тамирчид амжилт дүүрэн эхлүүлээ. Тухайлбал, тэмцээний 4 дэх өдрийн

байдлаар гар бууны хурдан буудлагын эмэгтэй төрөлд оролцсон ангийн холбооны зангилгааны дарга, ахмад Б.Хандсүрэн III байр, цэрэгжлийн буудлагын тэмцээний төрөлд эмэгтэй баг тамирчид нэгдсэн дүнгээр III байр, цэргийн 3 төрөлтийн тэмцээнд оролцсон баг тамирчид багийн нийлбэр дүнгээр III байр эзэлсэн бахдам сайхан амжилтыг үзүүлээд байна.